

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2021 оны 4 сарын байдлаар/

№	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт дүн
1	Нийт үзлэг	26740	40001	23666	16862	2487	109756
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	8870	14612	9229	3037	2341	38089
3	Идэвхтэй хяналтын үзлэг	2147	8755	6848	1722	0	20472
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	9499	8070	2773	4031	147	24520
5	Нийт төрөлт	439	137				576
6	Хэвтэн эмчлүүлэгчид	2337	1337		1236	21	4931
7	Нас баралт	5	42	28			75

№	Үзүүлэлт	<u>2020.4</u>	2021.4	Өөрчлөлт
1	Нийт үзлэг	108983	109756	773
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	27018	38089	11071
3	Идэвхтэй хяналтын үзлэг	20520	20472	-48
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	27772	24520	-3252
5	Нийт төрөлт	554	576	22
Үүнээс	Гэрийн төрөлт	4	3	-1
	Охидын төрөлт	36	30	-6
	Охидын төрөлтийн эзлэх хувь	6.4	5.2	-1.2
6	Хэвтэн эмчлүүлэгчид	5508	4931	-577
7	Нас баралт	95	75	-20
	0-1 насны эндэгдэл	7	5	-2
	1-5 насны эндэгдэл	2	1	-1
	Хурц халдварт өвчин	95	18	-77

Үзүүлэлт	хэмжих нэгж	2010.4 сар	2021.4 сар	өөрчлөлт
Нялхасын эндэгдэл	1000 амьд төрөлтөд	12.5	8.6	-3.9
Үр хөндөлт	1000 амьд төрөлтөд	341.1	340.2	-0.9
Үүнээс охидын	хувь	7.3	12.1	4.8
Хурц халдварт өвчин	10000 хүн амд	13.5	2.5	-11
БЗДХ	10000 хүн амд	19.8	6.9	-12.9
Үүнээс өсвөр үе	хувь	10	14	4
Хүүхдийн хяналт /0-1 нас/	хувь	72	77.07	5.07
Хүүхдийн хяналт /1-5 нас/	хувь	33	43.2	10.2

I. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 109756 хүнд үзлэг шинжилгээ хийсний 53.3%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 4931 хүнийг 31609 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.4 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- Түргэн тусламжийн 3274 дуудлагад явж үйлчилсний 527/16%/ нь алсын дуудлага, 273/8.3%/нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 82.3% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
- Нийт эмийн сангууд 25539 жор хүлээн авч, 3тэрбум 930 сая төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.

- ЭЭСангуудад нийт 5272 жор ирсний 55,7% /2941/ нь ЭМДаатгалын, 2,6%/137/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 41,6% /2194/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 79,9% байна.

II. БҮРТГЭГДСЭН ӨВЧЛӨЛ, ЭНДЭГДЭЛ

- 4 сарын байдлаар 24520 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3252тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 62% нь шинэ өвчлөл байна.
- Үүнээс тэргүүлэх 5 өвчлөл нь:

1. **Хоол шингээх эрхтний өвчин-6565** /46,4% шүдний цоорол, 18,1% ходоодны, 7,9% элэгний үрэвсэл/

2. Амьсгалын тогтолцооны өвчин-3376

3. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-3237 /Артерийн даралт ихдэх 56%, зүрхний ишемит өвчин 20%

4. Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин-2827

5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-2286

- 4 сарын байдлаар 531 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 10 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 3-р, өвчлөл 102 тохиолдлоор өссөн байна.
- Осол гэмтлээр нас барагсдын 10%/1/нь амиа хорлосон-/Мн-1/, 40% /4/нь зам тээврийн осол-/Бд-1, Гт-1, Нн-1, Өо-1/, 50% /5/ нь бусад ослоор /Бо-2, Цц-2, БОЭТ-1/ тус тус эндсэн байна.
- Осол гэмтлээр нас барагсад нь 80% /8/ эрэгтэй ба 2 нь эмнэлэгт хүргэгдсэн боловч хоног болоогүй нас барсан байна. Бусад тохиолдлууд эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүй газар дээрээ нас барсан байна.
- Оны гарсаар 75 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 13,3% нь осол гэмтлээр, 18,6% нь хорт хавдраар, 6,6% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 2,6% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна. Нийт нас баралтын 10 нь эмнэлэгт, бусад нь гэртээ, хээр гадаа нас барсан байна.
- Нялхсын эндэгдлийн 5 /Бо-1, Мо-1, Но-1, БОЭТ-2/ тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 8,6% байна.
- Нялхсын эндэгдэл 2020 онд 42,8% нь эрт нярайн эндэгдэл байсан бол 2021 онд 40% нь эрт нярайн, 60% нь сараас дээш насны хүүхэд 2 байгаа ба 1 нь хатгаагаар, 1 нь осол гэмтлээр эндсэн байна
- БОЭТөвд 5 эндэгдэл тохиолдож задлан шинжилгээ 80% тай байна. Үндсэн оношийн зөрөө байхгүй.
- **Нас баралтын шалтгаан:**

1. **Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-30**

2. Хорт хавдарын нас баралт-14

3. Бэртэл хордлого гадны шалтгаант нас баралт-10

4. Хоол шингээх эрхтний өвчин-9

5. Төрөх, перинаталь үед үүсэх эмгэг-3/ нярай/

6. Уушигны хатгаа 2

7. Бөөрний эмгэг 2

8. Үжил-1

9. Уушигны бөглөрөлттэй-2

10. Мэдрэлийн өвчин-1

III. ЭХ, ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

- Нийт 576 эх төрж 579 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 22 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна.
- Нийт төрөлтийн 5,8% / 30/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Бо-1, Бу-1, Гт-1, Сэ-1, Хб-6, Хх-1, Цо-1, Шб-8, Өо-4, Эх-5, Бг-1/.
- 4 сарын байдлаар 197 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 340,2 байгаа нь өнгөрсөн оноос 0,9-р буурсан үзүүлэлт байна. Өсвөр насны охидын үр хөндөлт-24/12,1%/ Бд-2, Бу-2, Гт-1, Мн-2, Но-1, Нн-1, Хб-1, Цо-2, Цц-2, Шб-2, Өо-4, Эх-2, Бг-2/ байна.
- Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд 0,9-р буурч, охидын үр хөндөлт 4,8-р нэмэгдсэн байна.
- 4 сарын байдлаар сард дундажаар 5448 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 60,2% эзэлж байгаа нь өнгөрсөн оноос нэмэгдсэн хэдий ч хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 12 хүүхэд жингийн

алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байгаа ба 16 хүүхэд туранхай, 12 хүүхэд өсөлтийн хоцрогдолтой байна.

- 0-1 насны хүүхдийн хяналт 5.07-р, 1-5 хүртэлх насны хүүхдийн хяналт 10,2-р тус тус нэмэгдсэн байна.

IV. ХАЛДВАРТ ӨВЧИН

- Он гараад 118 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 126 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 3.3%-г салхинцэцэг, 7.6% сүрьеэ, 5%-г гар хөл амны өвчин, 4.2% цусан суулга, 42.3%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
- БЗДХ-н 50% нь жирэмсний үзлэгээс 22% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 32% нь өвчний учир амбулатороор, 18% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.

ДЭЭРХ ҮЗҮҮЛЭЛТЭЭС ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. Охидын төрөлт, үр хөндөлт, БЗДХ өмнөх жилээс нэмэгдэх хандлагатай байгаад анхаарч өсвөр үеийн эрүүл мэнд, ялангуяа нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг сайжруулахад илүү үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай.
2. Үр хөндөлт хүсээгүй жирэмслэлт өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байгаад анхаарч нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн дундах жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээ, зорилтод бүлгийн хяналт, үр хөндөлтийн дараахь зөвлөгөө, давтан үр хөндөлтөөс сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах
3. Гэрийн 3 төрөлт нь алслагдсан хөдөө орон нутагт биш, аймгийн төв дээр тохиолдсон байгаа нь хөдөө орон нутгаас ирсэн эхчүүдийн хяналт, төрөх дөхсөн эхчүүдэд өгөх зөвлөгөө, мэдээллийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.
4. БЗДХ-н 72 % нь идэвхгүй үзлэг тандалтаар илэрсэн байгаа нь хүн амын дундах өвчлөлийн тархалт өндөр байгааг харуулж байгаа ба урьдчилан сэргийлэх үзлэг, илрүүлэлтийг идэвхжүүлэх шаардлагатай.
5. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болсон хоол боловсруулах эрхтэний болон зүрх судасны эмгэгийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, мэдээлэл сургалт сурталчилгаа, эрт илрүүлэг хяналт эмчилгээг сайжруулах
6. Осол гэмтлийн өвчлөл өнгөрсөн оноос нэмэгдсэн байгаа ба өвчлөлийн 25.6%, нас баралтын 40% зам тээврийн осол байна. Мөн осол гэмтлийн өвчлөлийн 86,4% нь гадны шалтгаан, орчин нөхцөл, ажлын байрны аюулгүй ажиллагаатай, 13,5% хүчирхийллийн шалтгаантай байгаад анхаарч осол гэмтлийн өвчлөл нас баралтыг бууруулахад салбан дундын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.
7. Нас баралтын голлох шалтгаан нь цусны эргэлтийн тогтолцооны эмгэг буюу тархинд цус харвалт, зүрхний ишемит эмгэг зэрэг сэргийлж болох эндэгдэл тэргүүлж байгаа ба эрт илрүүлэлт, хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б. Мидэрсүрэн , Д. Гантогтох